



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.11 № 01/57

МЭДЭЭЛЭЛ ШУУДАН ХАРИЛЦАА
ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА Ц.ЖАДАМБАА
ТАНАА

Зөрчил арилгуулах тухай


“Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2013 оны үйл ажиллагаа, үр дүн”-д нийцлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх төслийн хөрөнгөөр 89.5 сая төгрөгийн өртөг бүхий харилцаа холбооны тоног төхөөрөмжийг “Мобиком” ХХК-ийн өмчид, мөн баруун бүсийн алслагдсан цэгт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх ажлыг гүйцэтгэсэн “Жи-Мобайл” ХХК-ийн үүрэн холбооны төслийн хөрөнгөөр үүссэн нийт 609.9 сая төгрөгийн өртөг бүхий харилцаа холбооны тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Жи-Мобайл” ХХК-ийн өмчид тус тус бүртгүүлсэн нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан /Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана/, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан /Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна/ заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг өгч байна.

Нийлбэр дүнгээр 699.4 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг хувийн аж ахуйн нэгжийн санхүүгийн бүртгэлд бүртгэсэн байгаа асуудлыг холбогдох журмын дагуу хүчингүй болгож төрийн өмчид бүртгэх ажлыг гүйцэтгэж 2014 оны 10 дугаар сарын 1-ний дотор багтаан биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг МШХХТГ-ын дарга Ц.Жадамбаа, Нягтлан бодогч Э.Хонгорзул нарт даалгав.

ШИНЖЭЭЧ



Ш.НАРАНБААТАР